



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2015 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

### Хууль, тогтоолын төслүүдийг нэн яаралтай хэлэлцүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16<sup>1</sup> дүгээр зүйлийн 16<sup>1</sup>.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Өрийн удирдлагын тухай болон холбогдох бусад хуулийн төсөл, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай”, “Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай”, “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Монгол Улсын Ерөнхий сайдын хүсэлтийг үндэслэн хэлэлцэх асуудлын тов, дарааллыг харгалзахгүйгээр Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлсүгэй.

2. Энэ захирамжийн 1 дэх заалтад заасан хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангахыг холбогдох Байнгын хорооны дарга нарт даалгасугай.

ДАРГА

3. ЭНХБОЛД



0000000095